Монгол улсын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтын харьцуулсан судалгаа

Н.Энххишиг[1], Б.Мягмарсүрэн[1], О.Хатанболд[1], С.Пүрэвсүрэн[1], С.Мөнхбат[1]

[1]АШУҮИС, Эм зүйн сургууль, Эмнэлзүйн эм зүй, менежментийн тэнхим
Цахим шуудан: Enkhkhishig493@gmail.com, Утас: 99223260

Түлхүүр үг:

Эмийн хангамж
Эмийн хүртээмж
Эмийн үнийн боломж

Товч утга:

Үндэслэл: Монгол улсын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт (ЗШЭЖ)-ыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын загвар жагсаалттай харьцуулан хийгдсэн судалгаа харьцангуй ховор байгаа нь энэхүү судалгааны ажлын үндэслэл боллоо. **Зорилго:** Монгол улсын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын загвар жагсаалттай харьцуулах. **Арга, аргачлал:** Монгол улсын ЗШЭЖ-ыг ДЭМБ-ын загвар жагсаалттай харьцуулан эргэмж когорт судалгааны загварыг ашиглан баримтын аргаар судлав. **Үр дүн:** ДЭМБ-ын 2019 оны 21 дэх загвар жагсаалтад 29 бүлгийн 570 эм 652 эмийн хэлбэрээр орсноос 47.4%-ийг ууж хэрэглэх эмийн хэлбэр, 28.6%-ийг халдварын эсрэг эм, 0.18%-ийг диализийн уусмал, 92%-ийг дан найрлагатай эм, 8%-ийг нийлмэл найрлагатай эм эзэлж байна. 2023 оны 23 дэх загвар жагсаалтад 30 бүлгийн нийт 520 эм 717 эмийн хэрэглэх хэлбэрээр орсон байна. Нийт бүлгийн хамгийн их хувийг буюу 26.5%-ийг халдварын эсрэг эмийн бэлдмэл эзэлсэн байна. Эмийг хэрэглэх хэлбэрээр нь авч үзвэл хамгийн их хувь (57.3%)-ийг уух эмийн хэлбэр эзэлж байна. Монгол улсын ЗШЭ-ийн Х дэх жагсаалтад 30 бүлгийн 519 эм 654 эмийн хэлбэрээр орсон ба эмийн бүлгийн хамгийн их хувь (13%)-ийг халдварын эсрэг эмийн бэлдмэл эзэлж байна. Жагсаалтад багтсан нийт эмийн 89.5% буюу 460 эм нь дан найрлагатай, 10.5% буюу 54 нь нийлмэл найрлагатай эм байна. Олгох нөхцөлөөр авч үзвэл 380 эмийг жороор, 75 эмийг жоргүй олгох ба 7 эмийг мансууруулах, 18 эмийг сэтгэц нөлөөт эмийн жороор, 35 эмийг зөвхөн амбулаторийн үйлчлүүлэгчдэд үйлчлэх эмийн сангаар олгохоор заажээ. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт жагсаалтад багтсан эмийн хэлбэрийн 42.5% (718), багийн эмчийн салбарт 4.2% (71)-ийг хэрэглэхээр заасан байна. Нийт 84 эмийн молекул эм судлалын ангилалаар давхардан орсон байна. **Дүгнэлт:** МУ-ын ЗШЭ-ийн IX, Х дэх жагсаалтад багтсан эмийн хамгийн их хувийг ууж хэрэглэх эм эзэлсэн нь мөн дан найрлагатай эм ихэнх хувийг эзэлж байгаа нь ДЭМБ-ын загвар жагсаалтуудтай ойролцоо байна.

Үндэслэл: Хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай, сонголт хийх боломж бүхий эмээр тасралтгүй, жигд хүртээмжтэй хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь улс орнуудын тулгамдсан асуудал байдаг билээ. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) “Нэн чухал эмийн үлгэрчилсэн жагсаалт’-ыг 1977 онд гаргаж, 1978 онд “Алматагийн тунхаг” хэмээх баримт бичигт “Хүн амыг нэн чухал эмээр хангах зорилт бол эмнэлгийн анхдагч тусламжийн найман элементийн нэг мөн’’ гэж тодорхойлсон юм. Ийнхүү зайлшгүй шаардлагатай эмийн загвар жагсаалт анх 1977 онд батлагдсанаас хойш 2-3 жил тутамд шинэчлэгдэж, 23 дэх жагсаалт 2023 онд батлагдсан байна.[1] ДЭМБ-ын загвар жагсаалт нь улс орнуудын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг боловсруулахад гол гарын авлага болдог бөгөөд 2022 оны байдлаар зайлшгүй шаардлагатай эмийн бодлогыг 137 орон хэрэгжүүлж байна.[2]

Эмийн хангамж, хүртээмжийг сайжруулах

зорилгоор манай улс Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт (ЗШЭЖ)-ыг өөрийн улс орны нөхцөлд тохируулан 1991 оноос эхлэн ДЭМБ-ын загвар жагсаалтад үндэслэн гаргасан ба жагсаалтыг 3-4 жил тутамд шинэчилж, 2020 онд 9 дахь жагсаалт, 2023 оны 06 дугаар сард 10 дахь жагсаалтыг гаргасан байна.

Хэдийгээр манай улсад анх зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг баталснаас хойш 33 жил болсон хэдий ч зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад багтсан эмүүд нь Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдэхгүй байх, эмийн нэр төрөл оновчгүй, хүртээмж болон хангалт муу, жагсаалтын дагуу эмээр хангах бодлого төдийлөн хэрэгжихгүй байгаа зэрэг алдаа дутагдал байсаар байна.[3] Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтын талаарх судалгаа ховор байгаа ба зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтуудыг хооронд нь болон ДЭМБ-ын жагсаалттай харьцуулан судалж, дараагийн жагсаалтыг гаргахад суурь мэдээллийг бүрдүүлэх зорилгоор энэхүү судалгааг явуулах шаардлагатай байгаа нь үндэслэл боллоо.

Зорилго: Монгол улсын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг ДЭМБ-ын загвар жагсаалттай харьцуулан эмийн нэр төрөл, хэрэглэх арга, хэлбэрийг судлах.


Арга, аргачлал: Монгол улсын ЗШЭЖ-ыг ДЭМБ-ын загвар жагсаалттай харьцуулан эргэмж когорт судалгааны загварыг ашиглан баримтын аргаар судлав. Монгол улсын Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан 1-10 дүгээр жагсаалт, ДЭМБ-ын Зайлшгүй шаардлагатай эмийн загвар жагсаалтаас урьдчилан боловсруулан судалгааны картын дагуу мэдээллийг цуглуулж, мэдээллийг Microsoft Excel программаар нэгтгэж, үр дүнгийн боловсруулалтыг хийв. Судалгааг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны (2022.12.16-ны өдрийн 2022/3-11) зөвшөөрөлтэйгөөр хийсэн.

Үр дүн: Монгол улсын ЗШЭ-н 1 дүгээр жагсаалтад 27 бүлгийн 221 эм багтсан бол X дүгээр жагсаалтад 30 бүлгийн 519 эм орсон байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Зайлшгүй шаардлагатай эмийн I-X жагсаалтыг харьцуулсан байдал


Үзүүлэлт		Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт									
		1	2	3	4	5	6	7	8	9	10
Батлагдсан он		1991	1993	1996	2001	2005	2009	2014	2017	2020	2023
Нийт эмийн тоо		221	222	267	274	277	329	519	574	569	519
Нийт эмийн хэлбэрээр		252	246	318	348	345	381	754	792	703	654
Эмийн бүлгийн тоо		27	27	27	27	27	27	29	27	29	30
Эмнэлгийн байгууллагын шатлал	Багийн эмчийн салбар	86	41	49	56	83	105	87	77	69	71
	Өрхийн эмнэлэг	-	-	-	-	121	-	-	-	-	-
	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	131	146	175	200	212	260	275	256	246	277
	Сум дундын эмнэлэг	167	-	-	243	241	339	353	-	-	-
	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	200	235	261	302	303	404	539	539	551	620
	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	-	-	-	-	-	-	586	-	-	-
	Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	223	261	297	340	336	426	667	703	700	718
	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	-	-	-	-	-	-	503	529	537	513

Манай улс эрүүл мэндийн тусламжийн бүх шатлалд үзүүлэх оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлтэд нэн тэргүүнд шаардагдах эмийг ДЭМБ-ын ЗШЭ-ийн талаарх үзэл баримтлалд тулгуурлан өөрийн орны хүн амын өвчлөлийн байдал, хэрэгцээнд тохируулан сонгож, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг гаргадаг. ЗШЭ-ийн 1-10 дугаар жагсаалтад орсон эмийн тоог ДЭМБ-аас гаргасан тухайн онд мөрдөгдөж байсан жагсаалтын эмийн тоотой харьцуулан судлав (Зураг-1).



Зураг 1. Монгол улсын ЗШЭЖ болон ДЭМБ-ын ЗШЭ-ийн загвар жагсаалтад орсон эмийн тоог харьцуулсан дүн

Зураг 1-ээс үзэхэд Монгол улсын ЗШЭ-ийн 1 дүгээр жагсаалтаас 6 дүгээр жагсаалтад орсон эмийн тоо ДЭМБ-ийн үлгэрчилсэн жагсаалтаас дунджаар 26.8%-иар бага, 7,8-р жагсаалтад дунджаар 10.1% илүү байсан бол 9,10 дүгээр жагсаалтад ойролцоо тооны буюу Монгол улсын ЗШЭ-ийн 10 дүгээр жагсаалтад нийт 519 эм, ДЭМБ-ийн ЗШЭ-ийн 23-р загвар жагсаалтад нийт 520 эм багтсан байна (Зураг 2).



Зураг 2. Монгол улсын ЗШЭ-ийн X дүгээр жагсаалтыг ДЭМБ-ын жагсаалттай харьцуулсан нь

Монгол улсын болон ДЭМБ-ын 2023 оны ЗШЭ-ийн жагсаалтад орсон эмийн нийт тоо, эмийн нийт хэлбэр, нийлмэл найрлагатай эмийн тоо, нийлмэл эмийн хэлбэр болон ерөнхий эмийн хэлбэрээр харьцуулан судлав (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Монгол улсын болон ДЭМБ-ын 2023 оны ЗШЭ-ийн жагсаалтад орсон эмийн тоо, хэлбэрийн харьцуулалт

Үзүүлэлт	Монгол улсын X жагсаалт		ДЭМБ-ын 23-р жагсаалт		Харьцуулсан хувь %
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Нийт эмийн тоо	519	100%	520	100%	-
Нийт эмийн хэлбэрээр	654	100%	717	100%	-
Нийлмэл эмийн тоо	54	10.4%	47	9.0%	1.4%
Нийлмэл эмийн хэлбэрээр	58	8.9%	59	8.2%	0.7%
Амьсгалын замаар хэрэглэх	17	2.6%	19	2.6%	0.0%
Тарилга, ампул	240	36.7%	208	29.0%	7.7%
Уруу хэрэглэх	308	47.1%	411	57.3%	-10.2%
Тосон түрхлэг, гель, крем	23	3.5%	32	4.5%	-1.0%
Гадуур хэрэглэх уусмал, нунтаг	22	3.4%	19	2.6%	0.8%
Суулгац	2	0.3%	5	0.7%	-0.4%
Лаа	11	1.7%	8	1.1%	0.6%
Цус цусан бүтээгдэхүүн	4	0.6%	-	0.0%	0.6%
Нүдний дусаалга, хамрын цацлага	27	4.1%	12	1.7%	2.4%
Наалт	-	0.0%	3	0.4%	-0.4%

Хүснэгт 2-оос үзэхэд Монгол улсын ЗШЭ-ийн 10 дүгээр жагсаалтад нийт 519 нэр төрлийн эм бичигдсэн ба нийт эмийн хэлбэрийг авч үзэхэд 654 эм бичигдсэн байна. Тухайлбал: Ибупрофен эм нь өвдөлт намдаах эмийн бүлэгт шахмал, капсул хэлбэрээр мигрень эмчлэх эмийн бүлэгт шахмалаар бичигдсэн бол ДЭМБ-ийн үлгэрчилсэн жагсаалтад шахмал, сироп 2 хэлбэрээр бичигдсэн байна. Бусад эмийн хэлбэрийг судлан үзэхэд уруу хэрэглэх эм ДЭМБ-ийн жагсаалтад орсон эмтэй харьцуулахад 10.2%-иар бага, тарилгаар хэрэглэх эм 7.7%-иар илүү бичигдсэн байна.

Монгол улсын ЗШЭ-ийн X жагсаалтад орсон эмүүдийг нийтийн үйлчилгээтэй эмийн сангаас иргэдэд олгох нөхцөлийг судлан үзэж зураг 2-т үзүүлэв.



Зураг 3. НҮЭС-аас иргэдэд ЗШЭ-ийн X жагсаалтад орсон эм олгох нөхцөл

Дээрх зургаас үзэхэд нийтийн үйлчилгээтэй эмийн сан ЗШЭ-ийн X жагсаалтад орсон эмүүдийн 69%-ийг жорын дагуу, 17%-ийг жоргүй, 2%-ийг мансууруулах эмийн жороор, 4%-ийг сэтгэц нөлөөт эмийн жороор иргэдэд олгодог байна.

Хэлцэмж: Өөрийн улсад мөрдөж буй ЗШЭЖ-ын өөрчлөлтийг үнэлэх, жагсаалтыг ДЭМБ-ын ЗШЭЗЖ-тэй харьцуулах ижил төстэй судалгааг бусад олон улс оронд хийсэн байдаг.[4-9] Хорват улсад хийсэн судалгаагаар ЗШЭЖ-д орсон эмийг ДЭМБ-ын ЗШЭЖ-тай харьцуулан судлахад 188 эм тухайн хоёр жагсаалтад хамрагдсан, харин халдварт өвчний эмчилгээнд хэрэглэх эм ялгаатай байсан байна.[4] БНХАУ-ын 2009 оны ЗШЭЖ-ыг ДЭМБ-ын ЗШЭЖ-тай харьцуулж үзэхэд ДЭМБ-ын ЗШЭЖ-д багтсан 132 эмийг Хятадын ЗШЭЖ-д хамруулсан байна.[5] Тежани (2014) нар Африкийн хөгжиж буй арван улсын ЗШЭЖ-д дүн шинжилгээ хийхэд ихэнх улс орнуудын ЗШЭЖ-д дунджаар 237 эм хамрагдсан ба 2013 оны байдлаар ДЭМБ-ын ЗШЭЗЖ-д байсан 350 эмтэй харьцуулахад ихэнх улс орны ЗШЭЖ нь ДЭМБ-ын ЗШЭЗЖ-тай 58.23%-иар адил эмийг агуулсан бол ойролцоогоор 47%-д ДЭМБ-ын ЗШЭЗЖ-д орсон эм ороогүй, 30%-д эмийг нэмж оруулсан байв.[9] Бид өөрийн орны ЗШЭ-ийн 10-р жагсаалтыг ДЭМБ-ын жагсаалттай харьцуулан судлахад 54.8% байв.

Вэи Зүо нарын (2020) 2018 оны БНХАУ-ын Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтын тайлбар судалгааны дүгнэлтэд фармакологийн ангиллаар Зүрх судасны бүлгийн эмийн бэлдмэл ихэнх хувийг эзэлсэн байна. Харин бидний судалгаагаар Монгол улсын ЗШЭЖ-ын IX, X дэх жагсаалтад халдварт өвчний эмчилгээнд хэрэглэх эмийн бэлдмэл хамгийн их хувийг эзэлж байгаа нь ялгаатай байна.[10] Itunuoluwa Adekoya нарын (2021) судалгаагаар ЗШЭЖ-

тай 138 орны жагсаалтад орсон антибиотикийн дундаж тоо 26 мөн 102 орны жагсаалтын антибиотикийн эзлэх хувь их байсан[11] нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байна.

Дүгнэлт: МУ-ын ЗШЭ-ийн Х дэх жагсаалтад багтсан эмийн хамгийн их хувийг ууж хэрэглэх эм эзэлсэн нь мөн дан найрлагатай эм ихэнх хувийг эзэлж байгаа нь ДЭМБ-ын загвар жагсаалтуудтай ойролцоо байна.

Ном зүй:

1. *П.Батхуяг "Монгол улсын зайлшгүй шаардлагатай эмийн лавлах" Улаанбаатар; 2006. х.13-20*
2. *Б.Оргил "Монгол улсын эмийн үндэсний бодлого" Улаанбаатар; 1993.х18-24*
3. *Төрөөс эмийн талаар баримтлах бодлого.Улаанбаатар; 2014*
4. *Kadic AJ, Zanic M, Skaricic N, Marusic A. Using the WHO essential medicines list to assess the appropriateness of insurance coverage decisions: a case study of the Croatian national medicine reimbursement list. PLoS One. 2014. doi:10.1371/journal.pone.0111474. 27.*
5. *Lu Y, Laing R. Comparison of the Chinese National Essential Medicines Lists with WHO Essential Medicines Model List. Utrecht: World Health Organization Winter meeting; 2010.*
6. *Xin Tian, Yaran Song, Xinping Zhang. National Essential Medicines List and policy practice: A case study of China's health care reform. BMC Health Services Research 2012, 12:401*
7. *Elizabeth F. Peacocke, Sonja L. MyhreI, Hakan Safaralilo FossI, Unni Gopinathan. National adaptation and implementation of WHO Model List of Essential Medicines: A qualitative evidence synthesis. PLOS Medicine. March 11, 2022. https://doi.org/10.1371/journal.pmed.1003944*
8. *Velisha Ann Perumal-Pillay, Fatima Suleman. Quantitative evaluation of essential medicines lists: the South African case study. BMC Health Services Research (2016) 16:687 DOI 10.1186/s12913-016-1937-x*
9. *Nav Persaud, Maggie Jiang, Roha Shaikh. Comparison of essential medicines lists in 137 countries. Bull World Health Organ 2019;97:394–404. doi: http://dx.doi.org/10.2471/BLT.18.222448*
10. *Zuo W, Mei D, Sun W, Tang X, Niu Z, Gao D, Zhang B. The interpretation of China national essential medicines list 2018. Expert Rev Clin Pharmacol. 2020 Feb;13(2):191-200. doi: 10.1080/17512433.2020.1713749. Epub 2020 Jan 20. PMID: 31914825.*
11. *Adekoya I, Maraj D, Steiner L, Yaphe H, Moja L, Magrini N, Cooke G, Loeb M, Persaud N. Comparison of antibiotics included in national essential medicines lists of 138 countries using the WHO Access, Watch, Reserve (AWaRe) classification: a cross-sectional study. Lancet Infect Dis. 2021 Oct;21(10):1429-1440. doi: 10.1016/S1473-3099(20)30854-9. Epub 2021 Jul 29. PMID: 34332706.*
12. *Tejani AH, Wertheimer A. International variations in essential medication lists. Innovations in Pharmacy. 2014;5(1):1–11.*
13. *Ш.Нэргүй "Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн хангамж болон бүртгэлд хийсэн зарим судалгаа" Эм зүйн ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2011; х30-39*
14. *П.Батхуяг "Зайлшгүй шаардлагатай эмийн зохистой хэрэглээ".Улаанбаатар.1998; х25-37*
15. *Д.Гэрэлтуяа "Монгол улсын хүүхдийн эмийн хүртээмж,үнэ өртөгийг судалса судалгаа". Улаанбаатар хот. 2018; х 15-20*
16. *ДЭМБ-ын олон улсын худалдаанд гарч байгаа эмийн бүтээгдэхүүнд олгох сертификатын схем. УБ.2005*
17. *Onella Charles Igho Onakpoya[2], Simran Benipal[1], Hannah Woods "Withdrawn medicines included in the essential medicines lists of 136 countries" Canada. 2019; 178-196*
18. *Wold Health Organization Model List of Essential Medicines-22nd list, 2021*
19. *Л.Уламбаяр "Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн хангалтад хийсэн зарим судалгаа". Улаанбаатар. 2008; х7-28*
20. *П.Батхуяг "Эмийн зохистой хэрэглээ ба эмийн эмчилгээний гарын авлага' Улаанбаатар. 2008;х56-99*
21. *N.J.HowardBA "Changes in the World Health Organisation essential drug list" USA. 2003. 2130*
22. *О.Дамба "Эмийн адил нэршил ба тунгийн лавлах" Улаанбаатар. 2007; х100-113*
23. *Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн 1-9-р жагсаалт, Монгол улсын эрүүл мэндийн яам*
24. *Р.Цэрэнлхагва "Эм зүйн албаны зохион байгуулалт" Улаанбаатар. 2005*

Comparison of essential medicines lists of Mongolia

Enkhkhishig N[1], Myagmarsuren B[1], Khatanbold O[1], Munkhbat S[1], Purevsuren S[1]

[1]Department of Clinical Pharmacy and Management, School of Pharmacy, MNUMS
E-mail: Enkhkhishig493@gmail.com, Tel: +976-99223260

Background: The availability of essential, safe, effective, quality, and affordable medicines is a critical issue in the healthcare system. Rational use of medicines contributes to the health of individuals and helps address public health challenges in countries. In our country, the list of essential medicines has been approved since 1991, and most recently, the "10th list of essential medicines" and "3rd list of children's essential medicines" were approved by order No. A/197 dated June 5, 2023.
Aim: To compare essential medicines lists in Mongolia
Materials and Methods: Mongolia's health care system was compared with the model list of the World Health Organization and studied using a retrospective cohort study.
Results: The 9th list of the Ministry of Health of Mongolia includes 569 drugs and 703 drugs of 30 groups, and a large number of pharmaceutical products, or 14.6%, are produced against pharmaceutical products, while the smallest product is 0.35% of pharmaceutical products. 401 of the benefits are prescribed for prescriptions, 81 for non-profit benefits and 12 for nutrients, 9 for prescription drugs with nutritional effects, and 35 fees for outpatient pharmacies. 43.9% (679) and 4.4% (69) of team physician care were assigned to use the drug treatment list included in the special specialty center and specialized specialty care list.
However, in the latest list of the Ministry of Health of Mongolia, 519 drugs of 30 groups were included in the form of 654 drugs in the X list. The largest percentage (13%) of the drug group is antidote. 89.5% or 460 of all drugs included in the list are single products and 10.5% or 54 are combined products. 380 profit prescriptions, 75 nutritional prescriptions, 75 absorptive prescriptions, and 35 fee-only pharmacies serving amateur users were ordered. 42.5% (718) and 4.2% (71) of team physician care were indicated to use the list of drug therapy included in the list of special specialty centers and specialized specialty care. The largest number of pharmaceutical products produced by the Ministry of Health, included in the IX and X of the Ministry of Health, are drugs included in the WHO model.
Conclusion: The list of essential drugs in our country is being developed for the 9th time based on the WHO model list, reflecting our country's characteristics. Each newly approved list has increased medicines and dosage forms compared to the previous list.

Keywords: Medicines supply, Medicines availability, Medicines price